

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар  
сарын . . .-ны өдөр

Улаанбаатар  
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дараах заалтуудыг тус тус нэмсүгэй.

1/ 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт:

“3/ Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол тус тус өөрийн хүсэлтээр.”

2/ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8, 9 дэх заалт:

“7/ Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан тухай нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баримт, лавлагаа;

8/ Иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл лавлагаа;

9/ Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан болзлоор тэтгэвэр тогтоолгох бол энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 7, 8-д заасан баримт бичгийг болон хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүний хөдөлмөрийн дэвтэр, тухайн үед оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, малчнаар ажилд томилсон, чөлөөлсөн тухай тушаал эсхүл хөлсөөр ажиллах (ажил гүйцэтгэх гэрээ, тэдгээртэй адилтгах) гэрээ, 1995 оноос хойш малчнаар ажилласныг нотлох “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ... оны тооллого”-ын бүртгэл, лавлагаа”.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "хөдөлмөрийн" гэсний дараа "хортой," гэж, "халуун" гэсний дараа "хүнд" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 2 дугаар заалтын "хөдөлмөрийн" гэсний дараа "хортой," гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . . дугаар

Улаанбаатар

сарын . . .-ны өдөр

хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ  
ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2018 оны . . . дугаар сарын . . .-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2018 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ